

**ЗӨВЛӨМЖ****#1. ЗӨВЛӨМЖ**

**Шүүхийн шийдвэр гүйцэтгэхээс татгалзах, хугацаа алдах, шүүхийн шийдвэрийг биелүүлэхийг үл зөвшөөрөхгүй байхад анхаарч ажиллах.**

Аймгийн ЗДТГ-аас аймгийн хэмжээнд шүүхийн шийдвэрийн биелэлт, гүйцэтгэл, түүний шийдвэрлэлтэд дүн шинжилгээ хийж хэвшүүлэх, үүний тулд гомдол зөрчлийн агуулга, хэлбэрийг ангилан судлах, мэдээ, тайлангийн загварыг шинэчлэн боловсруулах, дүн шинжилгээнд тулгуурлан зөрчлийн хэлбэр тус бүрд тохирсон урьдчилан сэргийлэх арга хэмжээг төлөвлөх, биелэлтэд хяналт тавьж ажиллах шаардлагатай боловч Дорноговь аймгийн хувьд шүүхийн шийдвэрийг биелүүлэх ажиллагаа хангалтгүй байна.

Тухайлбал, тус аймгийн Айраг сумын Засаг даргаар томилогдохоор нэр дэвшсэн С.Ганбаатар нь шүүхэд нэхэмжлэл гаргаснаар нэхэмжлэлийг Захиргааны хэргийн Анхан шатны шүүхийн шийдвэр болон Давж заалдах шатны шүүхийн магадлалаар, мөн Улсын Дээд Шүүхийн Хяналтын шатны Захиргааны хэргийн шүүхийн 2017 оны 01 дүгээр сарын 20-ны өдрийн 306 дугаар тогтоолоор С.Ганбаатарыг Айраг сумын Засаг даргаар томилохыг Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшинд даалгаж, шийдвэрлэжээ.

Мөн Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нь шүүхийн шийдвэрийг биелүүлэх хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхгүй байгаа үйлдэлд тус аймгийн Шүүхийн шийдвэр гүйцэтгэх газар зөрчлийн хэрэг үүсгэн 250.000 /хоёр зуун тавин мянган төгрөг/-өөр торгосон байна. Гэтэл аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нь шат, шатны шүүхийн шийдвэрийг биелүүлэх талаар тодорхой арга хэмжээ аваагүй, хууль, тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллахгүй хугацаа алдсан байна.

Энэ үйлдэл нь иргэд олон нийтийн зүгээс шүүх, төрийн байгууллагад итгэх итгэлийг алдагдуулсан явдал болсон гэж үзэхээр байна.



## #2. ЗӨВЛӨМЖ

**Аймаг, сумын засаг даргын нөөц хөрөнгийг зориулалтын дагуу зарцуулах, хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нөөц хөрөнгийн нийт батлагдсан төсвийн 30-с доошгүй хувийг байнга бэлэн байлгахад анхаарах**

Сангийн сайдын 2012 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн 239 дүгээр тушаалаар Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмыг баталсан. Журамд Засаг даргын нөөц хөрөнгийг Хүчтэй цасан болон шороон шуурга, ган, зуд, үер, газар хөдлөлт, цөлжилт, гал түймэр, хүн, мал, амьтны болон ургамлын гоц халдварт өвчин, хортон мэрэгчид тархах зэрэг байгалийн гамшигт үзэгдэл тохиолдсон, нийтийг хамарсан цөмийн болон цацрагийн осол гарсан үед түүнийг хохирлыг бууруулах, тархалтыг хязгаарлах, үр дагаврыг арилгах, үйлдвэрлэл, технологийн горим зөрчигдсөнөөс барилга байгууламж, шугам, сүлжээ, тоног төхөөрөмж эвдрэх, тээврийн хэрэгсэл сүйрэх, цацраг идэвхт болон химийн хорт бодис алдагдах зэрэг техникийн холбогдолтой томоохон осол гарсан тохиолдолд түүнийг таслан зогсоох, хохирлыг арилгахад, Засаг дарга хуулиар олгогдсон бүрэн эрхээ хэрэгжүүлэхтэй холбоотой цаг үеийн шинжтэй зарим арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулахаар тусгагдсан. Мөн энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгахад зарцуулахаар журамласан. Гэтэл Дорноговь аймгийн хувьд дээрх журмын хэрэгжилт хангалтгүй байна.

Тухайлбал, Зочид төлөөлөгчдийг хүлээн авах, шагнал, урамшуулал, буцалтгүй тусламж, уралдаан тэмцээн санхүүжүүлэх, тэмдэглэлт өдөр, ойн арга хэмжээнд зориулж нөөц хөрөнгийг зарцуулсан байна(Хавсралт 1-17).

Хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгах журам байсаар байтал тус аймгийн хувьд журмыг хэрэгжүүлээгүй байна.

Тухайлбал, Дорноговь аймгийн Засаг даргын 2017 оны нөөц хөрөнгө 700.000.000 төгрөг батлагдсан бөгөөд 2017 оны 11 дүгээр сарын байдлаар 598.341.253 төгрөг буюу нийт төсвийн 85.4 хувийг, 2018 онд 450.000.000 төгрөг батлагдсанаас 2018 оны 10 дугаар сарын байдлаар 450.000.000 төгрөгийг тус тус зарцуулсан нь Сангийн сайдын 2012 оны Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журмын 2.3 дугаар зүйлд “энэ журмын 2.1.1, 2.1.2 дахь хэсэгт заасан хохирлыг арилгахтай холбогдсон арга хэмжээг санхүүжүүлэхэд зориулж нийт батлагдсан хөрөнгийн 30-аас доошгүй хувийг Засаг даргын нөөцөд байлгана” гэснийг хэрэгжүүлээгүй байна.



Монгол Улсын Засгийн Газрын 2016 оны 03 дугаар сарын 14-ний өдрийн 153 дугаар тогтоолоор “Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын дагуу Дорноговь аймгийн сумууд иргэн, аж ахуйн нэгжид сум хөгжүүлэх сангаас эргэн төлөгдөх нөхцөлтэй зээл олгож байгаа бөгөөд аймгийн хэмжээнд сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлт хангалтгүй байна.

Тухайлбал, Замын-Үүд суманд 2011-2018 онд 51 иргэний нийт 691,318.716 төгрөг, Сайхандулаан суманд 2013-2015 онд, 22 иргэний 82.821.400 төгрөг, Эрдэнэ суманд 2011-2016 онд 14 иргэний 69.623.400 төгрөг тус тус гэрээний үүргийн дагуу эргэн төлөгдөөгүй байна (Хавсралт 18-20).

Иймд тус сангийн зээлийн эргэн төлөлтөд ач холбогдол өгч, Засгийн газрын 2016 оны 153 дугаар тогтоолоор батлагдсан Сум хөгжүүлэх сангийн хөрөнгийг бүрдүүлэх, зарцуулах, тайлагнах, хяналт тавих журам”-ын 5.3.2 дугаар зүйлд заасны дагуу сангийн үйл ажиллагаанд улирал бүр хяналт шалгалт хийж, дүнг тухайн сумын нийт иргэдэд мэдээлж, иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын хуралдаанаар хэлэлцүүлж ажиллах шаардлагатай байна.

### #3. ЗӨВЛӨМЖ

***Сум хөгжүүлэх сангийн зээлийн эргэн төлөлтийг сайжруулж, төсвийн хөрөнгийг үргүй зарцуулж буй үйлдлийг таслан зогсоох.***



Иргэн, аж ахуйн нэгжээс хандив авахын тулд байгууллагын дүрмийг батлахдаа зориуд хууль бус дүрэм батлан, тухайн байгууллагад хуульд нийцээгүй хандив авах эрх олгосон зөрчилтэй байна.

Тухайлбал, Дорноговь аймгийн Засаг дарга Т.Энхтүвшин нь 2017 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/72 дугаар захирамжаар аймгийн Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газрын дүрмийг баталсан байна. Энэхүү дүрмийн 3-р зүйлд тус газрын эрх үүргийг тодорхойлж өгсөн байх бөгөөд дүрмийн 3.2-т “Ажилчдын нийгмийн болон ажиллах нөхцөл боломжоор хангах зорилгоор зарим төрлийн төлбөртэй үйлчилгээг үзүүлэх, хандив, дэмжлэг, тусламж авах” гэж заажээ.

Үүний дагуу Говийн догшин ноён хутагт Д.Данзанравжаагийн мэлмий гийсний 215 жилийн ойн баяр наадмыг тэмдэглэн өнгөрүүлэхээр нийтдээ 152 иргэн, аж ахуйн нэгжээс 1.1 тэрбум төгрөгийн хандив цуглуулсан байна.

Дүрмийн 1.1-т Засаг даргын дэргэдэх Нийтлэг үйлчилгээний газрыг “Орон нутгийн төсөвт газар” мөн гэж тодорхойлжээ.

Орон нутгийн төсөвт газар нь Авлигын эсрэг хууль болон Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн үйлчлэлд хамаарах юм. Тэгвэл дүрмийн 3.2 дахь хэсэг болон тус дүрмийн хүрээнд иргэн, аж ахуйн нэгжээс хандив авсан үйлдэл нь Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17-р зүйлийн 17.1-д “Албан тушаалтан, төрийн болон нутгийн захиргааны байгууллага, нутгийн өөрөө удирдах байгууллага нийтийн хэрэгцээнд зориулан иргэн, хуулийн этгээдээс бэлэг, бусад санхүүгийн туслалцааг авах, хүсэхийг хориглоно” гэсэнтэй нийцэхгүй байна.

Мөн аймгийн Нийтлэг үйлчилгээний газар нь иргэн, аж ахуйн нэгжээс хандив авахдаа Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 17.3-т заасан “Албан тушаалтан хандив, санхүүгийн туслалцааг авахын өмнө өөрийн удирдлага, эсхүл эрх бүхий байгууллагаас зөвшөөрөл авсан байна” гэснийг хэрэгжүүлээгүй байна.

Иймд дээрх дүрмийн холбогдох хэсгийг хүчингүй болгож, хүчингүй болгосон талаар Авлигатай тэмцэх газарт хариу ирүүлэх, цаашид санаатайгаар хууль зөрчсөн үйлдлийг давтан гаргахгүй байхад анхаарч ажиллана уу.

#### #4. ЗӨВЛӨМЖ

**Хандив авах зорилгоор санаатайгаар хуульд нийцээгүй дүрэм баталж, хандив цуглуулсан үйлдлийг давтан гаргахгүй байхад анхаарч, цаашид аливаа дүрэм, журмыг хууль тогтоомжид нийцүүлэн гаргаж байх.**



## #5. ЗӨВЛӨМЖ

*Худалдан авах ажиллагаанд батлагдсан төлөвлөгөөг баримталж ажиллах, хэрэгжилтэд хяналт тавих.*

“Сайншанд сумын 1-р багийн хуучин орон сууцны барилгуудын дээвэр, дулаалга, гадна фасадны засварын ажил”-ыг гүйцэтгүүлэхээр НТШ зохион байгуулан “Тобэм” ХХК-тай “Ажил гүйцэтгэх гэрээ ОНТХО-НТШ-10/2018”-г 2018 оны 5 дугаар сарын 21-ний өдөр 187.9 сая төгрөгийн үнийн дүн бүхий гэрээ байгуулсан нь төлөвлөгөөгүй худалдан авалт байв.

“Дорноговь аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөө”-нд тусгагдаагүй дээрх ажилд тендер шалгаруулалт зохион байгуулж, гэрээ байгуулсан нь Төсвийн тухай хуулийн 46.1.5.–т **“тухайн бараа, ажил, үйлчилгээг санхүүжүүлэх хөрөнгийн эх үүсвэр батлагдсаны дараа худалдан авах ажиллагааг эхлүүлэх”** заалтыг зөрчсөн; мөн Худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа аймгийн ЗД-ын 2018.3.14-ний өдрийн А/241 тоот захирамж гаргасан нь Төсвийн тухай хуулийн 41.2.2-т. **“батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”** гэж заасныг тус тус зөрчсөн гэж үзэж болохоор байна.

**#6. ЗӨВЛӨМЖ**

***Худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж, хэд хэдэн тендер шалгаруулалт зохион байгуулах явдлыг таслан зогсоох***

Худалдан авах ажиллагааны нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт зохион байгуулах явдлыг таслан зогсоох шаардлагатай байна.

Тухайлбал, Сайншанд сумын замын гэрэлтүүлгийн ажилд 170.7 сая төгрөг төсөвлөсөн 1 ажил (Нээлттэй тендер шалгаруулалт зохион байгуулах ёстой байсан) байгааг 3 багц болгон хувааж харьцуулалтын аргаар тендер шалгаруулалтыг зохион байгуулж, дээрх 3 багц бүрд “Хосхан хөхий” ХХК-ийг шалгаруулсан байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.5-д заасан “Энэ хуулийн 8.1 дэх хэсэгт заасан босго үнэд багтаах, эсхүл нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийх зорилгоор нийт төсөвт өртгийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглоно” гэснийг зөрчиж байна.

Мөн дээрх худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 8.7.1-д “тендер шалгаруулалтын журмыг сонгохдоо бүх багцын нийлбэр өртгийг үндэслэл болгох” гэж заасныг мөрдөөгүй зөрчилтэй байна.



Орон нутгийн өмчийн газраас 2018 онд зохион байгуулсан 42 худалдан авах ажиллагааны үнэлгээний хороонд нэр бүхий 27 хүн томилогдсон байна. Дээрх худалдан авах ажиллагаанд ТББ, иргэний нийгмийн төлөөллөөр 4 хүн ажилласан байгаагаас Э.Эрдэнэбаатар 20 удаа, Т.Отгондэлгэр 14 удаа, Н.Өнөрцэцэг 8 удаа ажилласан байгаа бөгөөд цаашид бусад ТББ-уудын төлөөллийг үнэлгээний хороонд оруулах, ил тод байдлыг нэмэгдүүлэх талаар анхаарал хандуулах шаардлагатай байна.

Энэ нь Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 47.4-т “Худалдан авах ажиллагааны ил тод байдлыг хангах зорилгоор үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд **тухайн салбарын мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, орон нутагт тухайн нутаг дэвсгэрийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаас томилсон иргэн, Засаг даргын Тамгын газрын ажилтныг оролцуулна**” гэж заасан байдаг ч дээрх 42 худалдан авах ажиллагааны Үнэлгээний хорооны 2-оос бусдад нь мэргэжлийн холбоодын төлөөлөл, хувийн хэвшлийн, эсхүл төрийн бус байгууллагын хоёроос доошгүй төлөөлөгч, иргэний төлөөллийг хангалтай хэмжээнд оруулаагүй байна гэж дүгнэж болохоор байна.

## #7. ЗӨВЛӨМЖ

**Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд бусад талын оролцоог хангах талаар онцгойлон анхаарал хандуулах**



Дорноговь аймгийн Замын-Үүд сумын орон нутгийн өмчит “Чандмань бадрал” ХХК нь худалдан авах ажиллагаандаа Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 33 дугаар зүйд заасны дагуу бараа, ажил үйлчилгээ худалдан авахдаа харьцуулалтын аргыг хэрэглэлгүй шууд худалдан авалтыг удаа дараа зохион байгуулсан байна.

Тухайлбал, Тус компаний захирлаар ажиллаж байсан У.Санрайжав нь 2017 онд 42.000.000 сая төгрөгийн “гинжит трактор”-ыг худалдан авахдаа хуульд заасан харьцуулалтын аргыг хэрэглэлгүй хувь хүнээс шууд худалдан авалт хийсэн нь Авлигатай тэмцэх газарт хэрэг бүртгэлийн хэрэг нээн шалгагдаж байсан бол 2018 онд мөн ижил төрлийн өөрөө буулгагч авто машин худалдан авахдаа харьцуулалтын аргыг хэрэглэж, худалдан авах ажиллагаа зохион байгуулаагүй иргэн Алтансүхээс шууд худалдан авсан зөрчилтэй байна.

Иймд цаашид худалдан авах ажиллагааг зохион байгуулахдаа Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийг баримталж, худалдан авалтыг цахим хэлбэрт шилжүүлэх, худалдан авах ажиллагаа явуулж байгаа төрийн албан хаагчдын мэргэжлийн ур чадварыг дээшлүүлэх, гэрчилгээтэй албан хаагчдын тоог нэмэгдүүлж ажиллах нь зүйтэй юм.

## #8. ЗӨВЛӨМЖ

**Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон холбогдох тушаал, шийдвэр журам зааврыг үйл ажиллагаандаа мөрдөж хэвших, хяналт, ил тод байдлыг сайжруулах, цахим хэлбэрт бүрэн шилжүүлэх, худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн албан хаагчдын тоог нэмэгдүүлэх.**





## #9. ЗӨВЛӨМЖ

***Төсвийн тухай хуулийг мөрдөж ажиллах, хөрөнгийн зардлыг тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдэд зориулан зарцуулах, тухайн онд худалдан авсан хөрөнгө санхүүгийн тайланд тусахгүй өнгөрөх нөхцөл үүсгэж байгааг таслан зогсоох.***

Гадаадын иргэн харьяатын газар (ГИХГ) -ын Дорноговь аймаг дахь газар нь 2017 онд Замын-Үүд сумын төсөвт 700.0 сая төгрөгийн орлого төвлөрүүлж, орлогынхоо 30 хувьд нь 210.0 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт авах төлөвлөгөөг сумын ИТХ-аас баталсан байна. Улмаар сумын ИТХ хоёр удаагийн төсвийн тодотголоор дээрх мөнгийг гүйцэтгэлээр нь нэмэгдүүлж нийт 359.0 сая төгрөгийн хөрөнгийн санхүүжилт олгохоор болсон байна. Үүний дагуу УБ хот дахь ГИХГ-ын харьяа газруудаас улсын тэмдэгтийн (визийн) хураамжийн орлогоос 1,213.2 сая төгрөгийг Замын-Үүд сумын төсөвт төвлөрүүлсэн байна. Замын-Үүд сумын Захирагчийн ажлын албанаас нээлттэй болон харьцуулалтын аргаар тендер зарлаж, 295.5 сая төгрөгөөр 8 автомашин, 60.6 сая төгрөгөөр тавилга, тоног төхөөрөмж худалдан авч ГИХГ-т хүлээлгэн өгчээ.

Замын-Үүд сумын Засаг даргын захирамжаар дээрх 356.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгийг ГИХГ-ын Дорноговь аймаг дахь газрын данс бүртгэлд тусгахаар тогтоосон боловч ГИХГ-ын Дорноговь аймаг дахь газар нь дээрх хөрөнгүүдээс 3.0 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг дансандаа бүртгэсэн ба бусад хөрөнгө нь УБ хот болон бусад газарт тараагдсан тул бүртгэж аваагүй байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр худалдан авсан үндсэн хөрөнгийг улсын төсвийн байгууллагын өмчлөлд шилжүүлсэн нь Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24-т “хөрөнгө оруулалт гэж төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг ойлгоно” гэсэн заалтыг зөрчсөн байна. ГИХГ-ын төсвийн төвлөрүүлэн захирагчийн 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дээрх 356.1 сая төгрөгийн үндсэн хөрөнгөөс 60.6 сая төгрөгийн тавилга, тоног төхөөрөмжийг бүртгэж, ТӨБЗГ-аас шийдвэр гараагүй тул 295.5 сая төгрөгийн автомашиныг бүртгээгүй тайлагнасан байна. Үүний улмаас Засгийн газрын 2017 оны санхүүгийн нэгтгэсэн тайланд дээрх үндсэн хөрөнгүүд тайлагнагдахгүй байх нөхцөл үүссэн байна.



Дорноговь аймаг дахь Аудитын газраас Замын-Үүд сумын ЗДТГ-ын данснаас хийгдэж буй хөрөнгө оруулалтыг орон нутгийн хөгжлийн сангаар дамжуулан хийх талаар зөвлөмж өгсөн. Зөвлөмжийн дагуу хөрөнгө оруулалтыг сумын орон нутгийн хөгжлийн сангийн дансаар дамжуулан хийж эхэлсэн боловч 2017 оны 9-р сараас төрийн санд шинээр “сумын хөрөнгө оруулалтын данс” гэх дансыг нээсэн байна.

Улмаар орон нутгийн хөгжлийн сангаар хэрэгжүүлэхээр иргэдээс санал авч эрэмбэлэгдсэн зарим ажлуудыг уг данснаас санхүүжүүлсэн байгаа нь **хөгжлийн сан болон сумын хөрөнгө оруулалтын үйл ажиллагаа давхардаж байгааг** харуулж байна.

Сумын удирдлагыг хэрэгжүүлэхтэй холбоотой **хөрөнгийг зардлыг** “сумын хөрөнгө оруулалт” гэж нэрлэн бүтээн байгуулалтын ажилд зарцуулж байгаа нь дараах хууль тогтоомжийг зөрчиж байна.

Үүнд:

Засгийн газрын 2012 оны 30 дугаар тогтоолоор баталсан “орон нутгийн төсвийн суурь зарлага тооцох аргачлал”-ын 1.2.3, 6.1-т заасан **хөрөнгийн зардал**, Төсвийн тухай хуулийн 58 дугаар зүйлийн 58.4.1-т заасан сумын удирдлагын чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой **хөрөнгийн зардлыг** мөн хуулийн 58.4.3 - 58.4.10-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой зардалд зарцуулсан байна. Өөрөөр хэлбэл сумын **удирдлагын чиг үүргийг** хэрэгжүүлэхтэй холбоотой **хөрөнгийн зардлыг** Төсвийн тухай хуулинд заасан бусад чиг үүргийг хэрэгжүүлэхэд зарцуулсан байна.

## #10. ЗӨВЛӨМЖ

***Хөрөнгийн зардлыг буруу төлөвлөн өөр зориулалтаар зарцуулж байгааг таслан зогсоох, Төсвийн тухай хууль, Засгийн газрын тогтоолоор баталсан журмыг мөрдөж ажиллах***



## #11. ЗӨВЛӨМЖ

***Замын-Үүд сум дахь төрийн байгууллагын автомашинаар хилээр зорчигч тээвэрлэх үйл ажиллагааг Замын-Үүдийн боомтын зөвлөлийн эрх хэмжээний хүрээнд таслан зогсоож, хариу мэдэгдэх.***

Дорноговь аймгийн Замын-Үүд сум дахь төрийн байгууллагын эрх бүхий албан тушаалтнууд төрийн байгууллагын өмчлөлд бүртгэлтэй тээврийн хэрэгслийг ашиглан Замын-Үүд-Эрээний боомтоор “очер” дараалалгүйгээр зорчигч тээвэрлэж хууль бус ашиг, орлого олж байна. Түүнчлэн удирдах албан тушаалтнаас өгсөн чиглэлийн дагуу, бусад төрийн байгууллага, албан тушаалтны хүсэлтээр гэх мэт шалтгаанаар төрийн албан хаагч, тэдгээрийн хамаарал бүхий этгээдийг хилээр дараалалд оруулахгүй нэвтрүүлж давуу байдал олгож байгаа нь улсын хилээр хууль бус эд зүйл нэвтрүүлэх эрсдлээс гадна авлига, ашиг сонирхлын зөрчил үүсэх нөхцөл үүсгэж байна. Иймд дээрх үйлдлийг нэн даруй таслан зогсоох шаардлагатай. (Хавсралт 21).



## #12. ЗӨВЛӨМЖ

**Аудитын байгууллагаас жил бүр хийж буй бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу хийсэн гүйцэтгэлийн аудитын тайлангийн дагуу өгсөн зөвлөмж, шаардлагыг тухай бүр биелүүлж улс, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтыг бодитой төлөвлөх, хэрэгжилтэд тавих хяналтыг сайжруулах, үр ашиг, нөлөөг дээшлүүлэх..**

Зураг төсвийг бүрэн хийлгээгүй, үр ашигтай эсэх нь тодорхой бус төсөл, арга хэмжээнд төсөв баталсан нь хөрөнгө оруулалтын үр өгөөж, ашгийг бууруулж байна. Төсвийн тухай хууль, Барилгын тухай хууль, Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам зэрэгт шинээр баригдах барилга байгууламжийн техник эдийн засгийн үндэслэл, батлагдсан зураг төсөв, үр ашгийн тооцоо зэрэгт үндэслэн хөрөнгө оруулалтыг төлөвлөхөөр заасан байдаг боловч 2017 онд аймгийн ИТХ зураг төсөл нь бэлэн болоогүй, батлагдаагүй 3 төсөл арга хэмжээнд 2,138,4 сая төгрөгийн төсөв батлуулсан байна. Үүнд, Эрдэнэ сумын ААНБ, айл, өрхийг нэгдсэн халаалт, цэвэр, бохир усны шугамд холбох ажил (325.4 сая төгрөг), Сайншанд сумын 6-р багийн Иргэдийн хөгжлийн төвийн барилга (400 сая төгрөг), Усан спорт сургалтын төвийн барилга (1412 сая төгрөг) зэрэг болно. Эдгээр Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4, Барилгын тухай хуулийн 24.1.1, 25.2.5, 37.1.3 дахь заалтуудтай нийцэхгүй байгаа бөгөөд төлөвлөлт үндэслэлгүй болох, гэрээнд заасан хугацаанд ашиглалтад орохгүй байх, ажил чанаргүй хийгдэх нөхцөлийг бүрдүүлж байна.



## #14. ЗӨВЛӨМЖ

***Гэрээнд тусгагдсаны дагуу ТАХ-ний үе шатны ажлын явц, хэрэгжилтэд тавьж буй захиалагчийн хяналтын чанарыг сайжруулах***

Тухайлбал, Монгол Улсын Үндэсний ир баяр наадам, Ардын хувьсгалын 97 жилийн ойг тохиолдуулан Замын-Үүд сумын баяр наадмыг 2018 оны 07 дугаар сарын 6-7-ны өдрүүдэд тэмдэглэн өнгөрүүлэх Сумын Засаг даргын А/174 тоот захирамж батлагдан гарсан бөгөөд баяр наадмыг зохион байгуулах комисс 2018 оны 07 дугаар сарын 02-ны өдөр хуралдаж, наадмын талбай дээр үйл ажиллагаа явуулах иргэдээс 10.000 төгрөгийн хураамж авах шийдвэрийг гарган, нийт 41 иргэнээс 402.300 төгрөг, 30 юаньтай хураан авсан байна.

Цаашид иргэн, аж ахуйн нэгжээс хууль эрх зүйн үндэслэлгүй төлбөр авахгүй байхад анхаарч ажиллах нь зүйтэй.



Захиалагч байгууллагын хүсэлтээр ажлын даалгаврыг өөрчилж гүйцэтгэсэн, гэрээ байгуулах эрх олгох тухай захирамж дээрх үнийг өөрчилж ажил гүйцэтгэх гэрээ байгуулсан, техникийн техникийн тодорхойлолтын дагуу барааг нийлүүлээгүй байна.

Тухайлбал, Замын-Үүд сумын ИТХ-ын тогтоолоор батлагдсан Хилийн шалган нэвтрүүлэх 0108-р ангийн спорт заалны шал хийх 48.0 сая төгрөгийн төсөл арга хэмжээг өөрчилж автомашины граж барьсан. Мөн ОНӨГ-аас Замын-Үүд сумын хуучны нийтийн орон сууцны засварын ажлыг 2 багц болгон тендер зарлаж, гэрээ байгуулсан бөгөөд дээрх багцуудад ороогүй 24-р байрын дээвэр, 109-р байрны гадна фасад, дулаалгын ажлыг хийсэн. Усан спорт, сургалтын төвийн барилгын ажилд “Баян могод” ХХК-тэй гэрээ байгуулж 1018,4 сая төгрөгөөр гүйцэтгүүлэх тухай аймгийн Засаг даргын 2017 оны А/396 тоот захирамж гарсан байхад гэрээ байгуулахдаа нийт үнийг 20,0 сая төгрөгөөр нэмэгдүүлж буюу 1038,4 сая төгрөгөөр гэрээ байгуулсан зэрэг зөрчилтэй байна.



Төрийн албан хаагчийг үндэслэлгүйгээр ажлаас чөлөөлдөг зөрчил арилахгүй байна. Тухайлбал, Дорноговь аймгийн хэмжээнд бүтцийн өөрчлөлтөөр 2017 онд 1 албан тушаалтан шүүхийн шийдвэрийн дагуу эргэн томилогдон нөхөн олговорт улсын төсвөөс 3,8 сая төгрөгийг, 2018 онд 2 албан тушаалтан шүүхийн шийдвэрийн дагуу эргэн томилогдон нөхөн олговорт улсын төсвөөс 17,3 сая төгрөгийг тус тус олгосон байна. Ажлаас үндэслэлгүй халагдсан, чөлөөлөгдсөн этгээдийг шүүхийн шийдвэрийн дагуу ажилд нь эгүүлэн томилж, ажилгүй байх хугацааны цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг захиргааны байгууллагаас нөхөн төлж төсвийг үр дүнгүй зарцуулж, хохирол учруулж байгаа учраас хууль бус шийдвэр гаргасан буруутай албан тушаалтнаар хохирлыг буцааж төлүүлж барагдуулах талаар арга хэмжээг зохион байгуулах шаардлагатай байна.

Захиргааны ерөнхий хуулийн 103 дугаар зүйлийн 103.1-т “иргэн, хуулийн этгээдийн хохирлыг барагдуулсны улмаас өөрт учирсан хохирлыг захиргааны байгууллага гэм буруутай албан тушаалтнаар буцаан төлүүлнэ. Хохирлыг гэм буруутай албан тушаалтнаар төлүүлэх үүргийг тухайн захиргааны байгууллагын дээд шатны байгууллагын дотоод аудитын нэгж хариуцна”, мөн Иргэний хуулийн 498 дугаар зүйлийн 498.5-д “...гэм хорыг арилгасан байгууллага өөрт учирсан хохирлыг тухайн гэм буруутай этгээдээс шаардаж гаргуулах эрхтэй” гэсэн заалтын хэрэгжилтийг хангуулах талаар удирдлага, зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах нь зүйтэй юм.

## #15. ЗӨВЛӨМЖ

**Төрийн мэргэшсэн албан хаагчдыг зөвхөн хуульд заасан үндэслэлээр ажлаас чөлөөлөх, албан тушаал дэвшүүлэх, удирдах албан тушаалд томилохдоо мерит зарчмыг удирдлага болгох, албан тушаалаас чөлөөлөхтэй холбогдуулан төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулж байгаа зөрчлийг давтан гаргахаас урьдчилан сэргийлэх.**



## #16. ЗӨВЛӨМЖ

**Албан тушаалтан  
томилогдсоноос хойш  
хуульд заасан хугацаанд  
хувийн ашиг сонирхол,  
хөрөнгө, орлогын  
мэдүүлэг гаргах  
чиглэлээр салбарын  
хэмжээнд зохион  
байгуулалтын арга  
хэмжээ авах, мэдүүлгээ  
хугацаандаа гаргаагүй  
албан тушаалтанд  
хариуцлага тооцох,  
хяналтыг сайжруулах.**

Авлигын эсрэг хуулийн 10 дугаар зүйлийн 10.3 дахь хэсэг, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.3-т заасны дагуу мэдүүлэг гаргагч албан тушаалтан хувийн ашиг сонирхлын болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ тухайн албан тушаалд сонгогдсон буюу томилогдсон өдрөөс хойш 30 хоногийн дотор, цаашид тухайн албан тушаалыг хашиж байгаа хугацаандаа жил бүрийн 02 дугаар сарын 15-ны дотор шинэчлэн гаргах үүрэгтэй. Гэтэл Дорноговь аймгийн хэмжээнд томилогдсоноос хойш 30 хоногийн дотор ХАСХОМ-гээ гаргаагүй буюу хугацаа хожимдуулсан 2018 онд 6 албан тушаалтан байна (Хавсралт 22).

Авлигын эсрэг хуулийн 13 дугаар зүйлийн 13.8-д заасны дагуу хувийн ашиг сонирхлын мэдүүлэг болон хөрөнгө, орлогын мэдүүлгээ хугацаа хожимдуулж гаргасан бол зөрчилд нь 1 албан тушаалтанд “ажлаас халах”, 5 албан тушаалтанд “сануулах” сахилгын хариуцлагыг тооцуулсан байна.





## #17. ЗӨВЛӨМЖ

**Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг хэрэгжүүлэх, журмын 4.1-д заасан хугацаанд холбогдох мэдээллийг ирүүлж хэвших.**

Захиргааны ерөнхий хуулийн шаардлагад нийцүүлэн “Албан тушаалтан өөрт ногдуулсан сахилгын шийтгэлийн талаарх мэдээллийг холбогдох этгээд болон нийтэд өөрийн зардлаар хүргэх арга хэмжээний журам”-ыг шинэчлэн боловсруулж, Авлигатай тэмцэх газрын даргын 2018 оны 11 дүгээр сарын 14-ний өдрийн А/123 дугаар тушаалаар баталсан бөгөөд уг журам нь захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн санд 2018 оны 11 дүгээр сарын 17-ны өдрийн 4036 дугаартай бүртгэгдсэн (журмыг <https://www.legalinfo.mn/law/details/13778?lawid=13778> - ээс татаж үзэх).

Журмын 4.1-т “Албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан талаарх мэдээллийг холбогдох этгээдэд хүргэсэн болон нийтэд мэдээлсэн өдрөөс хойш ажлын 5 өдрийн дотор журмын 2.1, 3.1-т заасан мэдээллийг тухайн албан тушаалтанд сахилгын шийтгэл ногдуулсан шийдвэр (хуулбар)-ын хамт эсхүл холбогдох мэдээллийг цахим хэлбэрээр Авлигатай тэмцэх газарт ирүүлнэ.” гэж заасан.